



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/2017

Мандалговь

Эзэмшил газрын
нэр өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт /Аривжих багийн зүүн хойно/ байршилтай "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ны Багануур-Чойрын Дундговь дахь салбарын нэр өөрчлөгдөж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ын Говийн бүсийн салбар нэртэй болсон тул 110/35/6 кВ-ын дэд станцын 9831м² /0.9831га/ газрыг зориулалтаар нь эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрхи байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2005 оны 55 тоот захирамжийн ТБЦДС ХК-ны Багануур-Чойрын Дундговь дахь салбарт холбогдох хэсэг, Мөн газар эзэмших 0009923 тоот гэрчилгээ тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200828